



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 644

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.“Дархан АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж болох 10 нэрийн, нийт 283,371,817.00 (хоёр зуун наян гурван сая гурван зуун далан нэгэн мянга найман зуун арван долоон) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 34,463,427.00 (гучин дөрвөн сая дөрвөн зуун жаран гурван мянга дөрвөн зуун хорин долоон) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.“Дархан АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Баясгаланд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн
64.4 дугаар тогтоолын хавсралт

“ДАРХАН АЗЗА” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
АШИГЛАЛТЫН ХУГАЦАА СУНГАХ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Үндсэн хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо ширхэг	Балансын үнэ Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Цаашид ашиглах хугацаа /жилээр/	Шинээр тогтоосон үнийн дүн /төгрөг/
1	Автогрейдер 90-32	9/3/2009	1	81,225,000	1	5,076,562.50
2	Бульдозер 90-35	9/3/2009	1	70,989,430	2	14,197,886.00
3	Нүүдлийн сууц	12/1/2009	1	25,470,380	1	2,547,038.00
4	Сейф	12/30/2009	1	204,150	2	40,830.00
5	Хөргөгч жижиг	1/24/2017	1	272,636	2	109,054.54
6	Битумын тогоо	1/1/2010	1	42,568,984	1	4,256,898.40
7	Гар таль	1/1/2004	1	96,100	1	48,050.00
8	Зөөврийн АБЗавод	1/1/2009	1	60,918,837	1	7,614,854.63
9	Компрессор шороо үлээгч	5/1/2014	1	1,174,000	2	391,333.33
10	Усны ёмкость	1/1/2014	1	452,300	2	180,920.00
				283,371,817	15	34,463,427
Нийт дүн			(хоёр зуун наян гурван сая гурван зуун далан нэгэн мянга найман зуун арван долоо)		(гучин дөрвөн сая дөрвөн зуун жаран гурван мянга дөрвөн зуун хорин долоо)	